

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН  
2010 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
НЭГТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

2010.11.15

**НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,  
НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ**

2010 оны жилийн тайлант хугацааны эхэнд нийт 177 ББСБ тусгай зөвшөөрөлтэй байсан бол 2010 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 17 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгож, 7 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор нийт 187 ББСБ тусгай зөвшөөрөлтэй байна.

Хорооны хуралдааны шийдвэрээр 2009 онд 2 ББСБ-ын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан бол 2010 он гарснаас хойш нийт 63 ББСБ-ын тусгай зөвшөөрлийн хугацааг тус бүр 3 жилийн хугацаатай сунгаад байна.

2010 оны гуравдугаар улирлын байдлаарх ББСБ-уудын тайлангийн нэгтгэлийн голлох статистик үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:


/Хүснэгт 1/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2010 оны III улирал	2009 оны III улирал	Өсөлт +/-, бууралт -/-
1	ББСБ-ын тоо	187	172	15
2	Хувь нийлүүлэгчдийн тоо	587	432	155
3	Ажиллагсадын тоо	868	759	109
4	Салбар нэгжийн тоо	60	57	3
5	Харилцагчдын тоо	110,399	84,484	25,915
6	Нийт актив /мянган төгрөгөөр/	121,755,609.3	89,320,627.4	32,434,981.9
	<b>Банкны салбарт эзлэх хувь</b>	<b>2.2%</b>	<b>2.2%</b>	<b>0.0%</b>
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	73,760,183.5	49,954,945.9	23,805,237.6
	<b>Банкны салбарт эзлэх хувь</b>	<b>2.4%</b>	<b>1.9%</b>	<b>0.5%</b>
8	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	89,437,539.9	68,888,094.1	20,549,445.8
	<b>Банкны салбарт эзлэх хувь</b>	<b>31.4%</b>	<b>27.6%</b>	<b>3.8%</b>
9	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	78,212,683.3	61,421,490.8	16,791,192.5
	<b>Банкны салбарт эзлэх хувь</b>	<b>32.3%</b>	<b>25.5%</b>	<b>0.07</b>
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мянган төгрөгөөр/	5,635,055.0	3,225,052.3	2,410,002.7
11	Нийт орлого /мянган төгрөгөөр/	21,275,481.0	19,596,686.5	1,678,794.5
12	Нийт зардал /мянган төгрөгөөр/	15,894,740.8	15,844,583.4	50,157.4
13	Тухайн үеийн ашиг /мянган төгрөгөөр/	5,380,740.1	3,752,103.1	1,628,637.0
1	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	15	8	7
	<b>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</b>	<b>8.0%</b>	<b>4.6%</b>	<b>3.4%</b>
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	19,183,852.05	12,694,871.0	6,488,981.1
	<b>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</b>	<b>15.8%</b>	<b>14.2%</b>	<b>1.6%</b>
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	14,509,709.11	9,250,929.8	5,258,779.3
	<b>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</b>	<b>19.7%</b>	<b>18.5%</b>	<b>1.2%</b>
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	7,907,526.03	6,337,361.8	1,570,164
	<b>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</b>	<b>8.8%</b>	<b>9.2%</b>	<b>-0.4%</b>
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	8,267,792.47	6,721,032.5	1,546,760.0

<b>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</b>		<b>10.6%</b>	<b>10.9%</b>	<b>-0.3%</b>
2	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	27	26	1
<b>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</b>		<b>14.4%</b>	<b>15.1%</b>	<b>-0.7%</b>
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	3,976,819.23	3,018,985.4	957,834
<b>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</b>		<b>3.3%</b>	<b>3.4%</b>	<b>-0.1%</b>
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	5,159,065.81	2,260,602.5	2,898,463.3
<b>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</b>		<b>7.0%</b>	<b>4.5%</b>	<b>2.5%</b>
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	3,623,651.95	2,713,231.2	910,420.8
<b>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</b>		<b>4.1%</b>	<b>3.9%</b>	<b>0.2%</b>
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	3,462,932.58	2,393,459.20	1,069,473.4
<b>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</b>		<b>4.4%</b>	<b>3.90%</b>	<b>0.5%</b>
3	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	49	47	2
<b>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</b>		<b>26.1%</b>	<b>27.3%</b>	<b>-1.2%</b>
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	5,917,746.56	5,724,465.1	193,281.5
<b>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</b>		<b>4.9%</b>	<b>6.4%</b>	<b>-1.5%</b>
Б	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	5,877,383.69	5,699,789.3	177,594.4
<b>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</b>		<b>6.6%</b>	<b>8.3%</b>	<b>-1.7%</b>
В	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	5,025,993.37	5,046,367.1	-20,373.7
<b>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</b>		<b>6.4%</b>	<b>8.2%</b>	<b>-1.8%</b>

Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоог өмнөх онуудтай харьцуулвал:

/График 1/



### **Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:**

2010 оны 3 дугаар улирлын байдлаар гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 15 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 8.0 хувийг, тэдгээрийн нийт актив ББСБ-ын нийт активын 15.8 хувийг, нийт олгосон зээл, түүнтэй адилтган тооцох актив нь нийт ББСБ-уудын олгосон зээл, түүнтэй адилтган тооцох активын 19.7 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-уудын эзэмшигчийн өмчийн 8.8 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 10.6 хувийг тус тус эзэлж байна. Тэдгээрийг гадаадын хөрөнгө оруулагчдын харьяалаар нь авч үзвэл, Дэлхийн Зөн Олон улсын байгууллагаас санхүүжигдсэн 1, Япон улсын хөрөнгө оруулалттай 7, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 4, Итали улсын хөрөнгө оруулалттай 1, АНУ-ын хөрөнгө оруулалттай 1, ОХУ-ын хөрөнгө оруулалттай 1 ББСБ тус тус үйл ажиллагаа явуулж байна.

**Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:**

2010 оны 3 дугаар улирлын байдлаар орон нутагт 27 ББСБ /1 дүгээр улирлын байдлаар 28 байсан ба 2 дугаар улиралд 2 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон/ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 14.4 хувийг, тэдгээрийн нийт актив нь нийт ББСБ-ын активын 3.3 хувийг, нийт олгосон зээл, түүнтэй адилтган тооцох актив нь нийт ББСБ-ын 7.0 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 4.1 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 4.4 хувийг тус тус эзэлж байна.

/График 2/



**Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дангаар эрхлэн явуулж буй ББСБ:**

2010 оны 3 дугаар улирлын байдлаар гадаад валютын арилжааг дангаар эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 46 ББСБ, зээл, гадаад валютын арилжаа эрхлэх зөвшөөрөлтэй 3 ББСБ буюу нийт 49 ББСБ зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 26.1 хувийг, тэдгээрийн нийт актив нийт ББСБ-ын активын 4.9 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 6.6 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 6.4 хувийг тус тус эзэлж байна.

ББСБ-уудын тусгай зөвшөөрөл авсан үйл ажиллагаагаар ангилвал дараах байдалтай байна:

/Хүснэгт 2/

№	Үйл ажиллагааны нэр төрөл	Үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоо /улирлаар/	
		2010 оны III улирал	2009 оны III улирал
1	Зээл	138	127
2	Факторингийн үйлчилгээ	6	5
3	Төлбөрийн баталгаа гаргах	7	5
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0	0
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	6	5
6	Гадаад валютын арилжаа	109	102
7	Итгэлцлийн үйлчилгээ	10	12
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	3
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	9	9
10	Хөрөнгө оруулалтын үйлчилгээ	1	1

2010 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлд 6 ББСБ буюу нийт ББСБ-ын 3.2 хувь /1 дүгээр улиралд 13 ББСБ буюу нийт ББСБ-ын 7.1 хувь, 2 дугаар улиралд 10 ББСБ буюу нийт ББСБ-ын 5.3 хувийг эзэлж байсан/ нь эхлэлтийн санхүүгийн тайлангаар, 20 ББСБ буюу нийт ББСБ-ын 10.7 хувь /1 дүгээр улиралд мөн 13 ББСБ буюу нийт ББСБ-ын 7.1 хувь, 2 дугаар улиралд 18 ББСБ буюу нийт ББСБ-ын 9.6 хувийг эзэлж байсан/ нь өмнөх үеүдийн санхүүгийн тайлангийн дүнгээр тус тус хамрагдлаа.

## ХОЁР. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.1 Активын бүтэц, өөрчлөлт:

ББСБ-уудын тайлант хугацааны нийт активын хэмжээ, бүтцийг өмнөх онтой харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна.

/Хүснэгт 3/

№	ХӨРӨНГӨ	2010 оны III улирал		2009 оны III улирал		Өөрчлөлт	
		мян. төг	хувь	мян. төг	хувь	мян. төг	хувь
<b>A</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>116,896,770.6</b>	<b>96.0%</b>	<b>85,125,841.5</b>	<b>95.3%</b>	<b>31,770,929.1</b>	<b>37.3%</b>
1	Мөнгөн хөрөнгө	34,772,760.3	28.6%	29,653,256.4	33.2%	5,119,503.9	17.3%
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	1,824,090.0	1.5%	3,176,964.2	3.6%	-1,352,874.2	-42.6%
3	Нийт зээл	73,760,183.5	60.6%	49,954,945.9	55.9%	23,805,237.6	47.7%
	(Зээлийн эрсдлийн сан)	3,917,222.5	3.2%	3,257,045.3	3.6%	660,177.1	20.3%
4	Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага	1,634,528.0	1.3%	5.5	0.0%	1,634,522.5	2970238 9.3%
	(Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан)	0.0	0.0%	5.5	0.0%	-5.5	-100.0%
5	Нийт факторингийн тооцооны авлага	365,564.2	0.3%	350.0	0.0%	365,214.2	104346. 9%
	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	350.0	0.0%	350.0	0.0%	0.0	0.0%
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	695,510.3	0.6%	254,536.8	0.3%	440,973.5	173.2%
7	Бусад хөрөнгө	7,761,706.7	6.4%	5,343,183.5	6.0%	2,418,523.2	45.3%
<b>Б</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>4,858,838.6</b>	<b>4.0%</b>	<b>4,194,785.9</b>	<b>4.7%</b>	<b>664,052.7</b>	<b>15.8%</b>
8	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/	4,858,838.6	4.0%	4,194,785.9	4.7%	664,052.7	15.8%
	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	6,426,723.2	5.3%	5,500,590.2	6.2%	926,133.1	16.8%
	(Хуримтлагдсан элэгдэл)	1,567,884.6	1.3%	1,305,804.2	1.5%	262,080.3	20.1%
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>121,755,609.3</b>	<b>100.0%</b>	<b>89,320,627.4</b>	<b>100.0%</b>	<b>32,434,981.9</b>	<b>36.3%</b>

2010 оны 3 дугаар улирлын байдлаар нийт актив өмнөх оны мөн үеэс 36.6 хувиар өссөн бол зээлийн үлдэгдэл нь нийт активын 60.6 хувийг эзэлж байгаа нь ББСБ-уудын үндсэн эрхэлж буй үйл ажиллагаа нь зээлийн үйл ажиллагаа хэвээрээ байгааг харуулж байна.

**2.2 Зээлийн багцын чанар:**

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

/Хүснэгт 4/

№	Ангилал	2010 оны III улирал		2009 оны III улирал		Өөрчлөлт	
		мян. төг	хувь	мян. төг	хувь	мян. төг	хувь
1	Хэвийн зээл	66,293,185.2	89.9%	42,116,130.3	84.3%	24,177,054.9	57.4%
2	Хугацаа хэтэрсэн зээл	1,958,797.1	2.7%	2,896,667.9	5.8%	-937,870.8	-32.4%
3	Чанаргүй зээл. Үүнээс:	5,508,201.2	7.5%	4,942,147.8	9.9%	566,053.5	11.5%
	а/ Хэвийн бус	1,199,861.2	1.6%	1,533,045.6	3.1%	-333,184.3	-21.7%
	б/ Эргэлзээтэй	1,461,466.3	2.0%	1,518,011.9	3.0%	-56,545.6	-3.7%
	в/ Муу	2,846,873.7	3.9%	1,891,090.3	3.8%	955,783.4	50.5%
<b>Нийт</b>		<b>73,760,183.5</b>	<b>100.0%</b>	<b>49,954,945.9</b>	<b>100.0%</b>	<b>23,805,237.6</b>	<b>47.7%</b>

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 2010 оны 3 дугаар улирлын эцэст нийт зээлийн багцын үлдэгдэлд эзлэх хэвийн зээл 5.6 хувиар өссөн, хугацаа хэтэрсэн зээл 3.1 хувиар, чанаргүй зээл 2.4 хувиар тус тус буурсан байна

**ГУРАВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ**

ББСБ-уудын 2010 оны эхний хагас жилийн тайлант хугацааны нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал дараах байдалтай байна.

/Хүснэгт 5/

№	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2010 оны III улирал		2009 оны III улирал		Өөрчлөлт	
		мян. төг	хувь	мян. төг	хувь	мян. төг	хувь
<b>A</b>	<b>Өр төлбөр</b>	<b>27,050,287.5</b>	<b>22.2%</b>	<b>16,269,217.3</b>	<b>18.2%</b>	<b>10,781,070.2</b>	<b>66.3%</b>
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	5,635,055.0	4.6%	3,225,052.3	3.6%	2,410,002.7	74.7%
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	16,021,662.5	13.2%	8,890,588.3	10.0%	7,131,074.1	80.2%
3	Бусад эх үүсвэр	953,247.7	0.8%	1,072,896.2	1.2%	-119,648.5	-11.2%
	Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр	1,059.3	0.0%	1,059.3	0.0%	0.0	0.0%
	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	910,235.8	0.7%	602,393.3	0.7%	307,842.6	51.1%
	Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	3,007.0	0.0%	4,480.6	0.0%	-1,473.6	-32.9%
	Факторингийн үйлчилгээний өглөг	35,246.3	0.0%	0.0	0.0%	35,246.3	#DIV/0!
	Гадаад валютын арилжааны эх үүсвэр	3,699.4	0.0%	464,963.1	0.5%	-461,263.7	-99.2%
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	300,000.0	0.2%	0.0	0.0%	300,000.0	#DIV/0!
5	Төслийн зээлийн санхүүжилт	4,140,322.4	3.4%	3,080,680.5	3.4%	1,059,641.9	34.4%
	<b>Бусад өр төлбөр</b>	<b>5,267,781.9</b>	<b>4.3%</b>	<b>4,163,316.0</b>	<b>4.7%</b>	<b>1,104,465.9</b>	<b>26.5%</b>
6	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	801,874.1	0.7%	206,568.9	0.2%	595,305.3	288.2%
7	Бусад пассив	4,465,907.8	3.7%	3,956,747.1	4.4%	509,160.6	12.9%
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн өглөг	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	#DIV/0!
	<b>Нийт өр төлбөр</b>	<b>32,318,069.4</b>	<b>26.5%</b>	<b>20,432,533.3</b>	<b>22.9%</b>	<b>11,885,536.1</b>	<b>58.2%</b>
<b>Б</b>	<b>Эзэмшигчдийн өмч</b>	<b>89,437,539.9</b>	<b>73.5%</b>	<b>68,888,094.1</b>	<b>77.1%</b>	<b>20,549,445.7</b>	<b>29.8%</b>

9	Хувьцаат капитал	78,212,683.3	64.2%	61,421,490.8	68.8%	16,791,192.5	27.3%
10	Бусад өмч	942,681.8	0.8%	510,322.1	0.6%	432,359.7	84.7%
11	Сангууд	1,134,629.9	0.9%	1,136,877.4	1.3%	-2,247.6	-0.2%
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	8,223,408.7	6.8%	5,021,265.9	5.6%	3,202,142.8	63.8%
13	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	924,136.3	0.8%	798,137.9	0.9%	125,998.4	15.8%
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		<b>121,755,609.3</b>	<b>100.0%</b>	<b>89,320,627.4</b>	<b>100.0%</b>	<b>32,434,981.9</b>	<b>36.3%</b>

Тайлант хугацаанд өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 58.2 хувь, эзэмшигчдийн өмч 29.8 хувиар тус тус өссөн бөгөөд 2009 оны 3 дугаар улиралд нийт пассивын 22.9 хувийг нийт өр төлбөр, 77.1 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байсан бол 2010 оны 3 дугаар улирлын байдлаар нийт пассивт эзлэх өр төлбөр 26.5 хувь, эзэмшигчийн өмч 73.5 хувь болж өөрчлөгдсөн байна.

2009 оны 3 дугаар улирлын эцэст нэр бүхий 10 ББСБ нийт 3,225,052.3 мянган төгрөгийн итгэлцлийн үйлчилгээний өглөгтэй байсан бол 2010 оны 3 дугаар улирлын байдлаар 9 ББСБ-ын 5,635,055.0 мянган төгрөг байгаа нь нийт пассивын 4.6 хувийг эзэлж байна.

Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 6 ББСБ байгаагаас тайлант хугацаанд тэдгээрийн өглөг 910,235.8 мянган төгрөг байгаа бол ББСБ-аас гаргасан өрийн бичиг нийт 300,000.0 мянган төгрөг байна. Мөн нийт 924,136.3 мянган төгрөгийн 2-догч өглөг бүхий 6 ББСБ байна.

### ДӨРӨВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

2010 оны 3 дугаар улирлын байдлаарх нийт орлого өмнөх оны мөн үеэс 8.6 хувиар өссөн ба дараах бүтэцтэй байна.

/Хүснэгт 6/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2010 оны III улирал		2009 оны III улирал		Өөрчлөлт	
		мян. төг	хувь	мян. төг	хувь	мян. төг	хувь
1	<b>ХҮҮГИЙН ОРЛОГО</b>	<b>14,828,780.4</b>	<b>69.7%</b>	<b>10,336,174.2</b>	<b>52.7%</b>	<b>4,492,606.2</b>	<b>43.5%</b>
	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	13,936,455.5	65.5%	9,880,894.7	50.4%	4,055,560.8	41.0%
	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	530,469.7	2.5%	275,168.6	1.4%	255,301.1	92.8%
	Үнэт цаасны хүүгийн орлого	44,250.8	0.2%	2,236.0	0.0%	42,014.8	1879.0%
	Бусад хүүгийн орлого	317,604.4	1.5%	177,874.9	0.9%	139,729.5	78.6%
2	<b>ХҮҮГИЙН БУС ОРЛОГО</b>	<b>5,872,744.3</b>	<b>27.6%</b>	<b>8,973,480.4</b>	<b>45.8%</b>	<b>-3,100,736.1</b>	<b>-34.6%</b>
3	<b>ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	<b>512,657.0</b>	<b>2.4%</b>	<b>282,157.2</b>	<b>1.4%</b>	<b>230,499.7</b>	<b>81.7%</b>
4	<b>ЕРДИЙН БУС ОРЛОГО</b>	<b>61,299.3</b>	<b>0.3%</b>	<b>4,874.7</b>	<b>0.0%</b>	<b>56,424.6</b>	<b>1157.5%</b>
	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>21,275,481.0</b>	<b>100.0%</b>	<b>19,596,686.5</b>	<b>100.0%</b>	<b>1,678,794.5</b>	<b>8.6%</b>

Нийт орлогод эзлэх нийт хүүгийн орлогын хувь хэмжээ 43.5 хувиар өсөхөд хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого, үнэт цаасны хүүгийн орлого голлох нөлөөг үзүүлсэн.

Харин хүүгийн бус орлогын үзүүлэлтүүд дараах байдалтай байна:

/Хүснэгт 7/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2010 оны III улирал		2009 оны III улирал		Өөрчлөлт	
		мян. төг	хувь	мян. төг	хувь	мян. төг	хувь
<b>1</b>	<b>Арилжааны орлого</b>	<b>1,512,518.2</b>	<b>25.8</b>	<b>4,451,805.4</b>	<b>49.6</b>	<b>-2,939,287.2</b>	<b>-66.0</b>
1.1	Гадаад валютын арилжааны орлого	1,512,518.2	25.8	4,451,805.4	49.6	-2,939,287.2	-66.0
1.2	Үнэт цаасны арилжааны орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
<b>2</b>	<b>Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого</b>	<b>3,017,770.6</b>	<b>51.4</b>	<b>3,696,467.1</b>	<b>41.2</b>	<b>-678,696.5</b>	<b>-18.4</b>
2.1	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	3,017,770.6	51.4	3,696,467.1	41.2	-678,696.5	-18.4
2.2	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
<b>3</b>	<b>Санхүүгийн үйлчилгээний орлого</b>	<b>1,342,455.6</b>	<b>22.9</b>	<b>825,207.9</b>	<b>9.2</b>	<b>517,247.7</b>	<b>62.7</b>
3.1	Санхүүгийн түрээсийн орлого	24.1	0.0	3,115.2	0.0	-3,091.1	-99.2
3.2	Итгэлцлийн үйлчилгээний орлого	1,116.0	0.0	132.1	0.0	983.8	744.5
3.3	Мөнгөн гуйвуулгын орлого	469,251.0	8.0	293,538.5	3.3	175,712.5	59.9
3.4	Картын үйлчилгээний орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.5	Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	50,805.5	0.9	51,136.7	0.6	-331.2	-0.6
3.6	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	488,706.2	8.3	313,573.1	3.5	175,133.2	55.9
3.7	Бусад	332,552.7	5.7	163,712.3	1.8	168,840.5	103.1
	<b>НИЙТ</b>	<b>5,872,744.3</b>	<b>100.0</b>	<b>8,973,480.4</b>	<b>100.0</b>	<b>-3,100,736.1</b>	<b>-34.6</b>

Хүүгийн бус орлого нь өнгөрсөн оны мөн үеэс 34.6 хувь буюу нийт орлогын багцад эзлэх хувь хэмжээний хувьд 18.2 хувиар буурсан байна.

Тайлант хугацааны нийт зардлын бүтэц дараах байдалтай байна:

/Хүснэгт 8/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2010 оны III улирал		2009 оны III улирал		Өөрчлөлт	
		мян. төг	хувь	мян. төг	хувь	мян. төг	хувь
<b>1</b>	<b>ХҮҮГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,720,105.2</b>	<b>10.8%</b>	<b>1,014,516.7</b>	<b>6.4%</b>	<b>705,588.5</b>	<b>69.5%</b>
<b>2</b>	<b>ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ</b>	<b>11,646,126.2</b>	<b>73.3%</b>	<b>12,374,578.5</b>	<b>78.1%</b>	<b>-728,452.2</b>	<b>-5.9%</b>
<b>3</b>	<b>БОЛЗОШГУЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,601,622.9</b>	<b>10.1%</b>	<b>1,782,565.1</b>	<b>11.3%</b>	<b>-180,942.1</b>	<b>-10.2%</b>
<b>4</b>	<b>ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>213,976.4</b>	<b>1.3%</b>	<b>180,224.1</b>	<b>1.1%</b>	<b>33,752.3</b>	<b>18.7%</b>
<b>5</b>	<b>ЕРДИЙН БУС ЗАРДАЛ</b>	<b>30,753.3</b>	<b>0.2%</b>	<b>9,518.2</b>	<b>0.1%</b>	<b>21,235.1</b>	<b>223.1%</b>
<b>6</b>	<b>ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ</b>	<b>682,156.7</b>	<b>4.3%</b>	<b>483,180.8</b>	<b>3.0%</b>	<b>198,975.9</b>	<b>41.2%</b>
	<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>15,894,740.8</b>	<b>100.0%</b>	<b>15,844,583.4</b>	<b>100.0%</b>	<b>50,157.4</b>	<b>0.3%</b>

Нийт зардал өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар өссөн байх хэдий ч энэ нь нийт орлогын өсөлтийн 8.6 хувьтай харьцуулахад эерэг үзүүлэлт юм.

2010 оны 3 дугаар улирлын тайлан тэнцлээр ББСБ-ын салбарын хувьд нийт 5,380,740.14 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласнаас нэр бүхий 145 ББСБ 6,100,268.4 мянган төгрөгийн цэвэр ашигтай, нэр бүхий 36 ББСБ 719,528.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан бол 6 ББСБ ашиг, алдагдалгүй байна.

**ТАВ. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

ББСБ-ын 2010 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 2008 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

- нийт өөрийн хөрөнгө 89,620,309.39 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 85,760,171.42 мянган төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт (1) нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа 103.01 хувь, (2) өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа 104.57 хувь, (3) нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 72.55 хувь;

- түргэн борлогдох актив 36,534,723.28 мянган төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 19,547,093.76 мянган төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 186.91 хувь;

- гадаад валютаар олгосон зээлийн өрийн үлдэгдэл, касст байгаа бэлэн валют, банкиндах валютын харилцах дансан дахь үлдэгдэл нийт 16,318,047.26 мянган төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 11,078,733.47 мянган төгрөг байгаагаас гадаад валютын ханшийн эрсдлийн зохистой харьцаа 5.85 хувь;

- итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 5,635,054.95 мянган төгрөг, хувьцаат капитал 78,170,884.32 мянган төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний өглөг, хувьцаат капиталын харьцаа 7.21 хувь;

- нийт үндсэн хөрөнгө 2,233,986.11 мянган төгрөг, нийт актив 121,755,609.27 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгө, нийт активын харьцаа 1.83 хувь байгаа нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тус тус хангасан байна.

Харин активын эрсдэлийн санг 4,290,990.02 мянган төгрөгөөр байгуулбал зохихоос 135,551.60 мянган төгрөгөөр дутуу буюу нийт 4,155,438.43 мянган төгрөгөөр байгуулсан байна.

**ЗУРГАА. БҮЛГИЙН САНХҮҮГИЙН  
ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Хорооны 2008 оны 157 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх журам”-ын дагуу ББСБ-ын үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээрх шалгалтын дүнгээр санхүүгийн тайлан тэнцэлд үндэслэн холбогдох үзүүлэлтүүдийг тооцож бодитой үнэлгээ, дүгнэлт өгөхтэй холбогдуулан 2010 оны 1 дүгээр улирлаас эхлэн нийт ББСБ-уудыг активын хэмжээгээр нь 1,000,000.0 мянган төгрөг ба түүнээс дээш төгрөгийн активтай, 400,000.0 мянган төгрөгөөс 1,000,000.0 мянган төгрөг хүртэл активтай, 400,000.0 мянган төгрөг хүртэл активтай болон зөвхөн гадаад валютын арилжаа эрхэлдэг ББСБ гэсэн 4 бүлэгт хуваан бүлэг тус бүрийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тооцож ирсэн.

ББСБ бүрийн активын өөрчлөлтөөс хамаарч эдгээр бүлгүүдийн бүтэц нь улирал тутамд шинэчлэгдэж байдаг бөгөөд 2010 оны 3 дугаар улирлын байдлаарх бүлгүүдийн ерөнхий бүтэц дараах байдалтай байна:



/Хүснэгт 9/

№	Бүлэг	Бүлэгт хамаарах ББСБ-ын тоо	Бүлгийн нийт актив		Нэмэлт мэдээлэл
			Актив /мян.төг/	Салбарын нийт активт эзлэх хувь хэмжээ /хувь/	
1	Бүлэг 01	25	70,656,199.1	58.0	1,000,000.0 мянган төгрөгөөс дээш хэмжээний активтай
2	Бүлэг 02	69	36,390,921.7	29.9	400,000.0 мянган төгрөгөөс 1,000,000.0 мянган төгрөг хүртэл хэмжээний активтай
3	Бүлэг 03	44	8,790,741.9	7.2	400,000.0 мянган төгрөг хүртэл хэмжээний активтай
4	Бүлэг 04	49	5,917,746.56	4.9	Зөвхөн гадаад валютын арилжаа эрхэлдэг бөгөөд 44,210.5 мянган төгрөгөөс 1,058,239.3 мянган төгрөгийн активтай
<b>НИЙТ</b>		<b>187</b>	<b>121,755,609.3</b>	<b>100.0</b>	

2010 оны 3 дугаар улирлын байдлаар бүлгүүдийн татварын дараах цэвэр ашиг, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд дараах байдалтай байна.

а/ Тайлант үеийн татварын дараах цэвэр ашиг:

/Хүснэгт 10/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Татварын дараах цэвэр ашиг /мян. төг/	Салбарын нийт татварын дараах цэвэр ашигт эзлэх хэмжээ /хувь/
1	Бүлэг 01	4,154,014.9	77.2%
2	Бүлэг 02	1,225,288.4	22.8%
3	Бүлэг 03	-122,743.4	-2.3%
4	Бүлэг 04	124,180.2	2.3%
<b>НИЙТ</b>		<b>5,380,740.1</b>	<b>100.0%</b>

б/ Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт:

/Хүснэгт 11/

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Бүлэг 01 /хувь/	Бүлэг 02 /хувь/	Бүлэг 03 /хувь/	Бүлэг 04 /хувь/
1	<i>Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтүүд</i>				
А	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдлээр жигнэсэн активын харьцаа (10 хувиас багагүй байх)	75.10 хангасан	131.15 хангасан	174.03 хангасан	1304.82 хангасан
Б	Өөрийн хөрөнгө, эрсдлээр жигнэсэн активын харьцаа (20 хувиас багагүй байх)	75.78 хангасан	132.90 хангасан	177.39 хангасан	1400.10 хангасан

В	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа (10 хувиас багагүй байх)	59.14 хангасан	89.61 хангасан	95.62 хангасан	92.56 хангасан
2	<i>Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт</i>				
А	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа (8 хувиас доошгүй байна)	85.45 хангасан	835.42 хангасан	6943.40 хангасан	102649.24 хангасан
3	<i>Активын эрсдлийн сангийн хүрэлцээний үзүүлэлт</i>				
А	Активын эрсдлийн сангийн хүрэлцээ (+ илүү, - дутуу) /мянган төгрөгөөр/	17,886.88 мянган төгрөгөөр илүү байгуулсан	4,475.04 мянган төгрөгөөр дутуу байгуулсан	63,963.43 мянган төгрөгөөр дутуу байгуулсан	85,000.00 мянган төгрөгөөр дутуу байгуулсан
4	<i>Гадаад валютын эрсдлийн үзүүлэлт</i>				
А	Нэгж валютын хувьд (+/- 40 хувь)	2.26 хангасан	7.93 хангасан	8.16 хангасан	16.55 хангасан
Б	Нийт валютын хувьд (+/- 40 хувь)	2.26 хангасан	7.93 хангасан	8.16 хангасан	16.55 хангасан
5	<i>Итгэлцлийн үйлчилгээний өглөг, хувьцаат капиталын үзүүлэлт</i>				
А	Итгэлцлийн үйлчилгээний өглөгийн дүн хувьцаат капиталын (80 хувиас хэтрэхгүй)	15.87 хангасан	0.00 хангасан	0.00 хангасан	0.00 хангасан
6	<i>Үндсэн хөрөнгийн үзүүлэлт</i>				
А	Цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн дүн нийт активын (15 хувиас хэтрэхгүй)	13.06 хангасан	13.74 хангасан	11.27 хангасан	13.68 хангасан

Бүлгүүдийн актив, ашгийн үзүүлэлтүүдийг харахад “Бүлэг 01”-д хамаарах 25 ББСБ /нийт ББСБ-ын 13.4 хувь/ нь бүхий л үзүүлэлтүүдээр голлох байр суурийг эзэлж байна. Харин Хорооны 2009 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн “Валютын арилжааг цэгцтэй болгох зорилгоор зарим тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 28 дугаар тогтоол батлагдсанаар валют солих цэгийн үйл ажиллагаа эрхэлж байсан, цаашид эрхлэх хүсэлтэй аливаа этгээд нь банк бус санхүүгийн гадаад валютын арилжааг Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх эрх зүйн үндэс бүрэлдсэнээс хойш уг үйл ажиллагааг эрхлэхээр хүсэлтээ Хороонд ирүүлсээр байгаа бөгөөд тайлант хугацаанд уг үйл ажиллагааг дангаар эрхэлж буй 49 ББСБ /нийт ББСБ-ын 26.2 хувь/ нь 2010 оны 2 дугаар улирлын байдлаар 35,111.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байсан бол 3 дугаар улирлын байдлаар 124,180.2 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

## ДОЛОО. БУСАД

Дор дурдсан үндэслэлүүдээр гадаад валютын арилжаа эрхлэх ББСБ-уудын дүрмийн сангийн доод хэмжээг нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзэж 2010 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн Хорооны “Хорооны 2008 оны 169 дүгээр тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 147 дугаар тогтоолоор гадаад валютын арилжаа дангаар эрхлэх ББСБ-ын дүрмийн сангийн доод хэмжээг 50,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 100,000.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй банк бус санхүүгийн байгууллагууд болон тус тогтоолыг гарахаас өмнө банк бус санхүүгийн гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтээ ирүүлсэн хуулийн этгээдэд 2011 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон хэмжээнд хүргэхийг үүрэг болгосон:

1. Хорооны 2009 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн “Валютын арилжааг цэгцтэй болгох зорилгоор зарим тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 28 дугаар тогтоол батлагдсанаар олны нэршсэнээр “Найман шарга” валют солих цэгийн орчимд болон Улаанбаатар хотын бусад нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байсан валютын арилжаа эрхлэгч этгээдүүд нь, Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий ББСБ байгуулж, үйл ажиллагаа явуулж байгаа нь валютын арилжаа эрхлэгчдийн төрийн хяналт, зохицуулалтгүйгээр үйл ажиллагаа явуулж байсныг цэгцтэй болгох тухай Хорооны зорилго биелэгдсэн;
2. Гадаад валютын зах зээл дээр өрсөлдөх хуулийн этгээд /ББСБ/-ийн тооны хувьд өрсөлдөөний багтаамж хангагдсан, нөгөөтэйгүүр тооноос чанарын үзүүлэлтэд анхаарах зайлшгүй шаардлага бий болж байгаа /*тухайлбал, 2010 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар гадаад валютын арилжаа эрхлэх 50 ББСБ-ын 16 нь буюу 32.0 хувь нь тусгай зөвшөөрөл авсан хэдий ч үйл ажиллагаа явуулаагүй*/;
3. Хэдийгээр нэр бүхий 50 ББСБ-ын 40 нь буюу 80.0 хувь нь 50,000.0 мянган төгрөгөөс 100,000.0 мянган төгрөг хүртэлх хэмжээний дүрмийн сантай хэдий ч үйл ажиллагаа явуулаагүй 16 ББСБ нь эдгээр 40 ББСБ-д хамаарч байгаа нь ББСБ байгуулсан нэрийдлээр үйл ажиллагаагаа эрхэлдэггүй, эсвэл тогтвортой эрхэлдэггүй байх хандлага цаашид ч өсөх хандлагатай байгаа;
4. Нэр бүхий 50 ББСБ-аас 13 нь 2010 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар алдагдалтай ажилласнаас 8 нь 50,000.0 мянган төгрөгөөс 100,000.0 мянган төгрөг хүртэлх хэмжээний дүрмийн сантайгаар үйл ажиллагаа явуулж буй ББСБ байгаа нь тэдгээрийн санхүүгийн зах зээлд эргэлдүүлэх хөрөнгийн хэмжээ нь төдийлэн хангалттай биш байгаа;
5. 100,000.0 мянган төгрөг хүртэлх хэмжээний дүрмийн сантай ББСБ-уудын 40 хувь /50 ББСБ-ын 32 хувь/ нь үйл ажиллагаа явуулаагүй, 20 хувь /50 ББСБ-ын 16 хувь/ нь алдагдалтай ажилласан, Монголбанк, Хороонд ирүүлбэл зохих 7 хоног, сар тутмын арилжааны мэдээ болон Хороонд ирүүлбэл зохих улирал тутмын санхүүгийн тайлан, мэдээг тогтмол ирүүлдэггүй зэргээс дүгнэхэд, хөрөнгийн хэмжээ багатай ББСБ-уудын хувьд холбогдох хууль тогтоомж, заавар журмыг баримталдаггүй, санхүүгийн хариуцлагын талаарх ойлголт дутмаг, ажиллаж буй боловсон хүчний мэргэжил, мэргэшлийн ур чадвар хангалтгүй, нөгөөтэйгүүр хөрөнгийн хэмжээ бага байх тусам компанийн засаглалын хэлбэр, түүний хэрэгжилт хангалтгүй байгаагийн нотолгоо болж байгаа.

## **БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР**